



**ТЭЭВРИЙН
САНХҮҮЖИЛТИЙН
ЗЭЭЛИЙН ЭРХ**

Зээлийн танилцуулга

“Тээврийн санхүүжилтийн зээлийн эрх нь Импортлогч, гадаад худалдаа эрхлэгч байгууллагад зориулсан, түүний бараа, бүтээгдэхүүний **Тээвэрлэлтийн төлбөр болон Гаалийн төлбөрийг санхүүжүүлэх** зорилготой бүтээгдэхүүн юм.”

Харилцагч та зээлийн эрхээ доорх 2 нөхцөлөөр ашиглах боломжтой. Үүнд:

- **Шугамын зээл:** Ложистикийн компаний тээврийн төлбөрийн нэхэмжлэл болон Гаалийн нэхэмжлэл ирэх үед зээлийн шугамаас олголтыг тухай бүрт авах.
- **Төлбөрийн баталгаа гаргуулах:** Ложистикийн компаний тээврийн төлбөрийн нэхэмжлэл болон Гаалийн нэхэмжлэл ирэх үед Банк тухайн нэмэхжлэлд 30-75 хоногийн төлбөрийн баталгаа гаргах.

Шугамын зээлийн нөхцөл	
Зээлийн хэмжээ	500,000,000 (таван зуун сая) төгрөг хүртэл
Зээлийн хугацаа	12 сар хүртэл
Зээлийн хүү	20.4%
Эргэн төлөлтийн нөхцөл	Нэхэмжлэлийн эсрэг олголтын бүрийн эргэн төлөлт 30-75 хоног
Ашиглаагүй зээлийн үлдэгдэлд бодогдох хүү	0.0%
Үндсэн барьцаа хөрөнгө	Бараа материалын үлдэгдэл болон Тээвэрлэгч ложистикийн компани дээрх Замд яваа бараа материал

Төлбөрийн баталгаа гаргуулах тохиолдолд баталгааны нөхцөл	
Баталгааны эрсдэлийн шимтгэл	6%

Бүрдүүлэх бичиг баримт

Зээлдэгчид тавигдах шаардлага

- Зээлдэгч буюу ложистикийн компаний захиалагч нь бараа ачилт хийлгэж байсан тодорхой хугацааны туршлагатай байх;
- Банканд зээлийн өргөдөл гаргах үед тээвэрлэлтийн идэвхитэй захиалгатай байх;
- Ложистикийн компанитай хамтран ажиллах/ захиалгын гэрээтэй байх;
- Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй бөгөөд чанаргүй зээлийн түүхгүй байх;
- Эрхэлж буй бизнесийн чиглэлээр 2-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

Зээлдэгчийн бүрдүүлэх материал, түүнийг хүлээн авах

- Байгууллагын албан хүсэлт;
- Байгууллагын улсын бүргэлийн гэрчилгээ, дүрам нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Тээврийн санхүүжилтийн зээлийн эрх нээлгэхийг зөвшөөрсөн талаар тухайн Байгууллагын эрх бүхий этгээд /төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэр;
- Байгууллагын сүүлийн 2 жилийн баталгаажсан санхүүгийн тайлан;
- Тээвэрлэгч буюу үйлчлүүлдэг Ложистикийн компани нь Банктай хамтын ажиллагааны гэрээтэй байх;
- Тээвэрлэгч буюу Ложистикийн компанитай хийсэн сүүлийн нэг жилийн тээвэр захиалгын гэрээ болон нэхэмжлэлийн баримт;
- Сүүлийн нэг жилийн Гаалийн татвар төлсөн баримт;

Тээвэрлэгчид тавигдах шаардлага

- Ложистикийн үйл ажиллагааны чиглэлээр 3-с доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
- Хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

Тээвэрлэгчийн бүрдүүлэх материал

- Хамтран ажиллах тухай албан хүсэлт
- Байгууллагын улсын бүргэлийн гэрчилгээ болон дүрэм нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, лиценз;



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn